



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: САГ-2021/7/СТА-ТЭЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2021 он</p>	<p>Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn</p> <p>Аудитын дөрөвдүгээр газрын захирал, тэргүүлэх аудитор: Я.Самбууням Утас: 260949 Цахим хаяг: sambuunyamy@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Д.Энхдалай Утас: 261885 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: П.Чанцалдулам Утас: 261740 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт.....	2
2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан.....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан.....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан.....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, түүний хүлээн зөвшөөрөхүйц байдал..	12
3.4 Материаллаг байдал.....	12
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт.....	13
3.5.1 Мөнгөн хөрөнгө.....	13
3.5.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт.....	14
3.5.3 Авлага.....	14
3.5.4 Урьдчилгаа.....	15
3.5.5 Бараа материал.....	16
3.5.6 Бусад эргэлтийн хөрөнгө.....	16
3.5.7 Урт хугацаат хөрөнгө оруулалт.....	17
3.5.8 Үндсэн хөрөнгө.....	18
3.5.9 Өр төлбөр.....	19
3.5.10 Засгийн газрын хувь оролцоо.....	20
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	21
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	23
3.8 Аудитын гол асуудал.....	23
3.9 Шилэн дансны мэдээлэл.....	24
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	24
3.11 Хойших үйл явдал ба дараагийн аудитаар анхаарах асуудал.....	24
4. Аудитын илрүүлэлт.....	25
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	30
6. Төлбөрийн акт, албан шаардлагын жагсаалт.....	36

Товчилсон үгийн жагсаалт

ААН	Аж ахуйн нэгж
ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БЗЭБХ	Борлуулах зориулалттай эргэлтэд буй хөрөнгө
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨААН	Төрийн өмчит аж ахуй нэгж
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТХН	Төсөл хэрэгжүүлэгч нэгж
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2021.05.05 № 1415

танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.7-д заасны дагуу Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



Д.ЗАНДАНБАТ

2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	6,130,857,980.9	6,997,579,321.4
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,782,740,778.4	2,780,608,075.7
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	728,105,139.4	887,904,541.8
33	АВЛАГА	1,668,131,339.7	1,385,233,681.4
34	УРЬДЧИЛГАА	104,708,012.8	527,312,635.8
35	БАРАА МАТЕРИАЛ	9,831,594.4	11,091,826.0
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	1,837,341,116.4	1,405,428,560.8
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,394,208,100.5	5,693,780,994.5
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	4,568,783,922.3	4,935,292,427.0
37100	Урт хугацаат хадгаламж	60,117,028.8	490,969,261.4
37200	Үнэт цаас	424,941,992.0	522,716,195.1
37300	Урт хугацаат зээл	4,083,724,901.6	3,921,606,970.5
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	825,424,178.1	758,488,567.5
39200	Биет хөрөнгө	691,105,445.6	608,279,900.4
39300	Биет бус хөрөнгө	15,322,737.7	20,474,184.2
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	118,995,994.8	129,734,482.8
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	11,525,066,081.4	12,691,360,315.8
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	6,872,011,359.2	7,080,724,031.2
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,470,582,726.5	1,423,873,286.2
41200	Богино хугацаат зээлийн өглөг	1,256,833,828.2	1,156,857,313.6
41300	Өглөг	154,462,318.6	220,096,235.8
41400	Урьдчилж орсон орлого	59,286,579.7	46,919,736.8
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,401,428,632.7	5,656,850,745.1
42100	Урт хугацаат үнэт цаас	2,173,068,797.3	2,394,367,029.5
42200	Урт хугацаат зээл	3,228,359,835.4	3,262,483,715.6
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,653,054,722.2	5,610,636,284.6
51	Засгийн газрын хувь оролцоо	4,653,054,722.2	5,610,636,284.6
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	105,127,805.5	97,211,551.3
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	1,362,382,139.0	1,357,200,340.6
51103	Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/	43,130,593.6	47,630,593.6
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	106,456,751.2	112,674,927.3
51200	Хуримтлагдсан үр дүн	2,956,398,123.4	3,912,816,643.6
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	59,907,863.5	60,238,337.6
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	651,445.9	3,863,890.6
51600	Нөөцийн сан	19,000,000.0	19,000,000.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	11,525,066,081.4	12,691,360,315.8

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,642,706,797.5	4,869,629,039.6
11	ТАТВАРЫН ОРЛОГО	982,076,589.0	820,121,472.4
110	Орлогын албан татвар	412,319,046.7	3,898,767.9
1103	ААН-ын орлогын албан татвар	40,430,278.9	3,898,767.9
1104	Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	371,888,767.8	-
118	Бусад татвар, төлбөр, хураамж	569,757,542.2	816,222,704.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,342,396,113.3	2,552,707,895.1
120	Нийтлэг татварын бус орлого	2,251,578,684.3	2,398,659,916.6
122	Тусламжийн орлого	87,598,789.2	154,047,978.4
124	Зээлийн орлого	3,218,639.8	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,318,234,095.2	1,496,799,672.2
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,445,867,106.6	2,786,510,594.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,444,267,065.6	2,786,143,798.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	504,022,241.8	680,630,812.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	112,952,040.2	136,410,925.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,473,110.0	17,049,605.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,884,033.3	10,395,427.2
2104	Хангамж, бараа материалын зардал	10,770,235.2	12,309,674.4
2105	Нормативт зардал	534,098.8	1,723,491.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,101,379.6	3,972,516.8
2107	Томилолт, зочны зардал	4,119,484.9	2,732,662.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	262,930,814.0	332,659,047.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	86,257,045.9	163,377,462.6
211	ХҮҮ	1,208,200,075.8	1,492,266,244.1
212	ТАТААС	9,782,820.0	4,153,245.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	722,261,927.9	609,093,497.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,600,041.0	366,795.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	2,196,839,690.9	2,083,118,445.0
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	54,408,274.2	36,044,104.2
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	733,172,559.2	916,889,700.5
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,518,075,405.9	1,202,272,848.7

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,939,969,441.2		1,939,969,441.2
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,128,677,797.6		1,128,677,797.6
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,068,647,238.8		3,068,647,238.8
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	362,757.9		362,757.9
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	4,992,343.0		4,992,343.0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-		-
7	Өмчид гарсан өөрчлөлт	71,471,466.5		71,471,466.5
8	Зарласан ногдол ашиг	-10,494,489.9		-10,494,489.9
9	Тайлант үеийн үр дүн	1,518,075,405.9		1,518,075,405.9
10	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,653,054,722.2		4,653,054,722.2
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-86,773,137.0		-86,773,137.0
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,566,281,585.2		4,566,281,585.2
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	19,154.7		19,154.7
14	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	26,046,597.6		26,046,597.6
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	6,218,176.0		6,218,176.0
16	Өмчид гарсан өөрчлөлт	-128,540,444.8		-128,540,444.8
17	Зарласан ногдол ашиг	-5,040,920.0		-5,040,920.0
18	Тайлант үеийн үр дүн	1,202,272,848.7		1,202,272,848.7
19	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,610,636,284.6		5,610,636,284.6

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,711,982,079.8	5,451,435,097.1
11	ТАТВАРЫН ОРЛОГО	900,926,103.0	767,877,302.1
110	Орлогын албан татвар	371,401,865.8	4,968,399.0
1103	ААН-ын орлогын албан татвар	40,430,278.9	4,968,399.0
1104	Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	330,971,586.9	-
118	Бусад татвар, төлбөр, хураамж	529,524,237.2	762,908,903.1
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	529,524,237.2	762,908,903.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,187,429,140.9	2,956,233,027.7
120	Нийтлэг татварын бус орлого	2,159,695,523.0	2,912,670,287.1
122	Тусламжийн орлого	27,733,617.8	43,562,740.7
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,623,626,835.9	1,727,324,767.2
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,379,394,885.3	4,028,093,690.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,379,394,885.3	4,028,093,690.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,772,813,806.3	1,717,431,404.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	110,403,634.4	138,263,509.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,858,832.5	18,151,970.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,469,828.1	9,342,029.0
2104	Хангамж, бараа материалын зардал	11,008,156.2	12,195,004.9
2105	Нормативт зардал	2,150,303.0	1,653,281.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,774,721.1	6,650,336.7
2107	Томилолт, зочны зардал	3,795,968.9	2,632,343.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	692,198,954.9	1,286,934,649.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	924,153,407.4	241,608,280.0
211	ХҮҮ	1,269,961,109.5	1,340,502,266.1
212	ТАТААС	9,782,820.0	10,563,596.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,326,837,149.6	959,596,423.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	332,587,194.4	1,423,341,407.0
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	309,814,241.8	142,692,112.4
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	928,101,637.5	509,980,095.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	928,101,637.5	509,980,095.3
2200	Дотоод эх үүсвэрээр	928,101,637.5	509,980,095.3
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-618,287,395.7	-367,287,982.9
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-60,091,119.5	-58,186,126.7
14	Бусад эх үүсвэр	373,283,142.8	104,577,643.1
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	193,620,770.2	-59,511,788.0
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	239,753,492.1	222,275,557.8
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-345,791,320.8	997,867,297.3
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,128,532,099.1	1,782,740,778.4
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,782,740,778.4	2,780,608,075.7

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,100,293,569,900.00	2,828,126,614,682.03	272,166,955,217.97	91.2
УРСГАЛ ЗАРДАЛ	1,923,464,807,000.00	1,791,136,307,578.68	132,328,499,421.32	93.1
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	521,522,427,200.00	475,925,936,273.05	45,596,490,926.95	91.3
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	75,512,353,900.00	67,674,684,466.49	7,837,669,433.51	89.6
Үндсэн цалин	48,461,582,100.00	44,130,907,448.65	4,330,674,651.35	91.1
Нэмэгдэл	17,173,589,100.00	14,683,225,326.77	2,490,363,773.23	85.5
Унаа хоолны хөнгөлөлт	3,197,212,500.00	2,819,816,741.05	377,395,758.95	88.2
Урамшуулал	6,150,508,700.00	5,512,892,888.02	637,615,811.98	89.6
Гэрээт ажлын хөлс	529,461,500.00	527,842,062.00	1,619,438.00	99.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,141,205,900.00	8,816,104,169.41	1,325,101,730.59	86.9
Тэтгэврийн даатгал	7,440,364,700.00	6,892,832,816.50	547,531,883.50	92.6
Тэтгэмжийн даатгал	640,371,400.00	496,612,405.36	143,758,994.64	77.6
ҮОМШӨ-ний даатгал	515,158,800.00	366,009,279.89	149,149,520.11	71.0
Ажилгүйдлийн даатгал	128,134,500.00	95,859,136.15	32,275,363.85	74.8
Эрүүл мэндийн даатгал	1,417,176,500.00	964,790,531.51	452,385,968.49	68.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,808,629,800.00	5,845,296,068.21	1,963,333,731.79	74.9
Гэрэл, цахилгаан	2,418,273,200.00	1,484,865,840.06	933,407,359.94	61.4
Түлш, халаалт	1,768,211,800.00	1,166,085,828.91	602,125,971.09	65.9
Цэвэр, бохир ус	369,984,300.00	169,649,787.81	200,334,512.19	45.9
Байрны түрээс	3,252,160,500.00	3,024,694,611.43	227,465,888.57	93.0
Хангамж, бараа материалын зардал	3,884,249,400.00	3,422,421,362.82	461,828,037.18	88.1
Бичиг хэрэг	754,352,000.00	668,693,553.76	85,658,446.24	88.6
Тээвэр, шатахуун	1,040,978,100.00	939,523,487.33	101,454,612.67	90.3
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	740,966,000.00	670,988,959.35	69,977,040.65	90.6
Ном, хэвлэл	225,405,700.00	132,537,991.24	92,867,708.76	58.8
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	74,830,100.00	45,926,480.00	28,903,620.00	61.4
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,047,717,500.00	964,750,891.14	82,966,608.86	92.1
Нормативт зардал	1,571,342,200.00	1,380,848,118.17	190,494,081.83	87.9
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	291,207,000.00	256,489,318.17	34,717,681.83	88.1
Хоол, хүнс	33,175,000.00	32,773,700.00	401,300.00	98.8
Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,246,960,200.00	1,091,585,100.00	155,375,100.00	87.5
Эд хогшил, урсгал засварын зардал	6,699,774,700.00	5,991,469,937.15	708,304,762.85	89.4
Багаж, техник, хэрэгсэл	2,990,559,600.00	2,617,717,117.85	372,842,482.15	87.5
Тавилга	44,448,000.00	26,507,340.00	17,940,660.00	59.6
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	785,881,100.00	730,986,317.00	54,894,783.00	93.0
Урсгал засвар	2,878,886,000.00	2,616,259,162.30	262,626,837.70	90.9
Томилолт, зочны зардал	1,388,226,600.00	777,113,202.67	611,113,397.33	56.0
Гадаад албан томилолт	107,167,800.00	19,737,965.00	87,429,835.00	18.4
Дотоод албан томилолт	1,168,311,800.00	692,598,089.67	475,713,710.33	59.3
Зочин төлөөлөгч хүлээн авах	112,747,000.00	64,777,148.00	47,969,852.00	57.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	339,364,047,200.00	310,705,913,681.17	28,658,133,518.83	91.6
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	331,589,110,000.00	305,155,293,805.40	26,433,816,194.60	92.0
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	172,497,100.00	129,365,532.81	43,131,567.19	75.0

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Даатгалын үйлчилгээ	148,231,000.00	127,404,259.42	20,826,740.58	85.9
Тээврийн хэрэгслийн татвар	32,515,600.00	13,819,566.00	18,696,034.00	42.5
Тээврийн хэрэгслийн оношилгоо	6,299,700.00	3,651,006.00	2,648,694.00	58.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,011,771,800.00	977,138,513.91	1,034,633,286.09	48.6
Газрын төлбөр	23,998,800.00	16,373,438.00	7,625,362.00	68.2
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,853,707,000.00	900,663,020.61	953,043,979.39	48.6
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3,525,916,200.00	3,382,204,539.02	143,711,660.98	95.9
Бараа үйлчилгээний бусад зардал	75,152,597,500.00	71,312,085,266.96	3,840,512,233.04	94.9
Бараа үйлчилгээний бусад зардал	72,849,086,700.00	70,216,191,666.82	2,632,895,033.18	96.4
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,303,510,800.00	1,095,893,600.14	1,207,617,199.86	47.6
ХҮҮ	972,576,395,000.00	932,819,892,635.71	39,756,502,364.29	95.9
Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	815,508,927,700.00	775,752,425,386.89	39,756,502,313.11	95.1
Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	815,508,927,700.00	775,752,425,386.89	39,756,502,313.11	95.1
Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	157,067,467,300.00	157,067,467,248.82	51.18	100.0
Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	157,067,467,300.00	157,067,467,248.82	51.18	100.0
ТАТААС	46,750,000,000.00	10,160,351,135.00	36,589,648,865.00	21.7
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	3,750,000,000.00	3,750,000,000.00		100.0
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	3,750,000,000.00	3,750,000,000.00		100.0
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	43,000,000,000.00	6,410,351,135.00	36,589,648,865.00	14.9
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	43,000,000,000.00	6,410,351,135.00	36,589,648,865.00	14.9
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	382,615,984,800.00	372,230,127,534.92	10,385,857,265.08	97.3
Засгийн газрын урсгал шилжүүлэг	378,462,193,800.00	369,274,999,370.92	9,187,194,429.08	97.6
Засгийн газрын дотоод шилжүүлэг	375,783,172,200.00	368,918,252,022.00	6,864,920,178.00	98.2
Засгийн газрын гадаад шилжүүлэг	2,679,021,600.00	356,747,348.92	2,322,274,251.08	13.3
Бусад урсгал шилжүүлэг	4,153,791,000.00	2,955,128,164.00	1,198,662,836.00	71.1
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	703,305,800.00	687,578,921.00	15,726,879.00	97.8
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	3,170,761,200.00	2,004,777,871.00	1,165,983,329.00	63.2
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	279,724,000.00	262,771,372.00	16,952,628.00	93.9
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,166,391,818,900.00	1,049,187,714,248.52	117,204,104,651.48	90.0
Барилга байгууламж	808,687,162,400.00	733,673,245,531.85	75,013,916,868.15	90.7
Их засвар	21,216,916,900.00	20,134,723,348.12	1,082,193,551.88	94.9
Тоног төхөөрөмж	324,509,960,600.00	283,937,594,677.34	40,572,365,922.66	87.5
Бусад хөрөнгө	11,977,779,000.00	11,442,150,691.21	535,628,308.79	95.5
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	10,436,944,000.00	-12,197,407,145.17	22,634,351,145.17	- 116.9
Эргэж төлөгдөх зээл	-214,072,377,700.00	-172,830,275,938.04	-41,242,101,761.96	80.7
Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	224,509,321,700.00	160,632,868,792.87	63,876,452,907.13	71.5
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,100,293,569,900.00	2,930,019,444,246.87	170,274,125,653.13	94.5
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,680,170,917,900.00	1,553,027,827,150.31	127,143,090,749.69	92.4
Улсын төсвөөс санхүүжих	1,680,170,917,900.00	1,553,027,827,150.31	127,143,090,749.69	92.4
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,478,286,682,300.00	1,388,227,419,543.73	90,059,262,756.27	93.9

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,920,535,100.00	11,825,048,477.08	-7,904,513,377.08	301.6
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,506,147,200.00	1,930,389,143.41	-424,241,943.41	128.2
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	0	54,714,354.39	-54,714,354.39	
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	1,472,860,000,000.00	1,374,417,267,568.85	98,442,732,431.15	93.3
ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	150,300,160,200.00	161,594,473,490.87	-11,294,313,290.87	107.5
Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	150,300,160,200.00	161,594,473,490.87	-11,294,313,290.87	107.5
БУСАД ЭХ ҮҮСВЭР	-208,464,190,500.00	-172,830,275,938.04	-35,633,914,561.96	82.9
Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	-208,464,190,500.00	-172,830,275,938.04	-35,633,914,561.96	82.9
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		158,331,338,905.61	-158,331,338,905.61	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		264,051,199,143.49	-264,051,199,143.49	
БАЙГУУЛЛАГЫН ТОО	4	4	-	100.0
Төсвийн байгууллага	4	4	-	100.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	3,748.00	3,531.00	217.00	94.2
Удирдах ажилтан	125	125	0.00	100.0
Гүйцэтгэх ажилтан	3,179.00	2,937.00	242.00	92.4
Үйлчлэх ажилтан	444	469	-25.00	105.6

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,211,949,795.84
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,110,035,495.84
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,425,041,949.95
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	379,015,559.65
210101	Үндсэн цалин	361,060,559.65
210104	Урамшуулал	17,955,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,042,807.96
210201	Тэтгэврийн даатгал	39,042,807.96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,106,276.00
210304	Байрны түрээс	24,106,276.00
2104	Хангамж, бараа материалын зардал	182,076,219.29
210401	Бичиг хэрэг	93,352,711.20
210402	Тээвэр, шатахуун	28,235,216.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	29,721,702.09
210404	Ном, хэвлэл	9,000,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	996,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	20,770,590.00
2105	Нормативт зардал	300,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	300,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	107,916,898.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	56,350,076.00
210602	Тавилга	22,485,812.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	11,040,410.00
210604	Урсгал засвар	18,040,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	321,574,994.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	309,250,562.00
210803	Даатгалын үйлчилгээ	117,612.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,370,820.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	836,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,371,009,195.05
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,299,293,097.05
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	71,716,098.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	684,993,545.89
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	957,600.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	957,600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	296,335,090.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	14,845,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	12,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	269,490,090.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	387,700,855.89
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	2,116,909.87
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	26,275,000.00
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	359,308,946.02
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	101,914,300.00
2200	Дотоод эх үүсвэрээр	101,914,300.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	101,914,300.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,211,949,795.84
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,211,949,795.84
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	38,935,000.00
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,154,457,599.05
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	871,354,546.79
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	147,202,650.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	150.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	150.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, төсвийн төлөвлөлтийг тооцоо судалгаанд үндэслэн хийх, төсвийн гүйцэтгэлийн тайланг иж бүрэн бэлтгэн хүргүүлэх, төсөл хөтөлбөрийг бүртгэх, тайлагнах бодлогын баримт бичиг боловсруулж, төсөл хэрэгжүүлэгч нэгжийн санхүүгийн ажилтнуудыг арга зүйгээр хангаж ажиллах талаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аудитын хоёрдугаар газрын ахлах аудитор П.Чанцалдулам гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Д.Энхдалай, аудитын дөрөвдүгээр газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2021 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 11-2/1908 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сангийн яамны зорилгыг “Монгол Улсын иргэдийн амьжиргааны түвшнийг дээшлүүлэхэд чиглэсэн санхүү, төсвийн таатай орчин бүрдүүлэх, санхүүгийн оновчтой удирдлагаар хангахад оршино” гэж тодорхойлсон байна.

Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл

- Санхүү, төсвийн удирдлагын чадавхыг бэхжүүлж, бүтэц, үйл ажиллагааг өөрчлөн сайжруулах;
- Санхүүгийн салбарын зохицуулалт, бүтцийн өөрчлөлтийн бодлого явуулах;
- Улс орны хөгжлийн ерөнхий чиг хандлага, стратегитай уялдуулсан санхүү, төсөв, татвар, гааль, хөрөнгө оруулалт, даатгалын бодлого, удирдлага, зохицуулалтаар хангах;
- Гадаадын санхүүжилттэй төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулалтаар хангах, боловсронгуй болгох, хэрэгжилтэд нэгдсэн хяналт тавих, гадаад, дотоод өрийн удирдлагыг бэхжүүлэх, хяналтыг чангатгаж үр нөлөөг дээшлүүлэх;
- Нягтлан бодох бүртгэл, аудитын бодлого, удирдлагаар хангах;
- Төрийн сангийн үйл ажиллагааг удирдлагаар хангах;
- Санхүүгийн дотоод хяналтын бодлого, удирдлагаар хангах;
- Засгийн газрын худалдан авах ажиллагааны бодлого, удирдлага, хяналт зохицуулалтыг сайжруулах;
- Яамны хэмжээнд удирдлагын үр ашигтай арга барил, туршлага нэвтрүүлэх, төлөвлөх, тайлагнах, хариуцлага тооцох тогтолцоог хөгжүүлэх замаар төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх;
- Улс орны санхүү, төсвийн аюулгүй байдлыг хангах, бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд шаардлагатай зөвлөгөө, үйлчилгээгээр хангах, сайд, Засгийн газрын танхимд үйл ажиллагаагаа үр нөлөөтэй, үр ашигтай явуулахад бүх талын дэмжлэг үзүүлэх;

- Засгийн газрын тэргүүлэх чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан санхүүгийн салбарын бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэхэд бусад яам, газруудын үйл ажиллагааны уялдааг хангах, санхүүгийн төлөвлөлт, зохицуулалтад шаардлагатай зөвлөгөө, үйлчилгээг мэргэшлийн өндөр түвшинд үзүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.13 дахь заалтыг үндэслэн Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны батлагдсан төсвийн хуваарьт Сангийн сайдын 2020 оны 165 дугаар тушаалаар өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын 2020 оны төлөвлөгөөнд нийт 41 ажил тусгагдсанаас 34 ажил бүрэн хэрэгжиж, Ковид-19 цар тахлаас шалтгаалан Монгол Улсад бүх нийтийн хөл хорионы онц байдал зарласан, мөн Засгийн газраас гаргасан тогтоол шийдвэрийн дагуу төлөвлөгөөт бус шалгалтууд хийсэнтэй холбоотойгоор төлөвлөгөөнд тусгасан 7 ажил хэрэгжээгүй, үнэлэх боломжгүй байна.

Тус газар нь тайлант онд харьяа 4 байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, 38.2 сая төгрөгийн төлбөрийн акт, 536.8 сая төгрөгийн албан шаардлага, санхүү, нягтлан бодох бүртгэлийг сайжруулах 44 зөвлөмж, өгч хэрэгжилтийг үнэлж, арга хэмжээ авч ажилласан байна.

Мөн урьд онуудад хийгдсэн санхүүгийн хяналт шалгалтаар илэрсэн зөрчилд тогтоогдсон төлбөрийн үлдэгдлээс нийт 55.1 сая төгрөгийг барагдуулсан байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, түүний хүлээн зөвшөөрөхүйц байдал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн нэгтгэсэн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС:2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлангийн нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2019 оны санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн нийт хөрөнгө 11,525,066.1 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 115,250.7 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг дахин тооцохдоо тайлангийн суурь үзүүлэлт, сонгосон хувийг өөрчлөөгүй бөгөөд 2020 оны санхүүгийн байдлын

нэгтгэсэн тайлангийн нийт хөрөнгө 12,691,360.3 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 126,913.6 сая төгрөгөөр тогтоов.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 1,782,740.8 сая, эцсийн үлдэгдэл 2,780,608.1 сая төгрөг болж, 997,867.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	57,443.2	53,736.1	-3,707.1
Банканд байгаа бэлэн мөнгө	1,522,289.1	2,688,930.2	1,166,641.1
Замд яваа мөнгөн хөрөнгө	-	22,450.8	22,450.8
Хадгаламж	203,008.5	15,491.0	-187,517.5
Дүн	1,782,740.8	2,780,608.1	997,867.3

Эх сурвалж: Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант оны мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 171,244.9 сая төгрөг төсөвт байгууллагын, 1,054,753.1 сая төгрөг төрийн өмчит байгууллагын, 1,554,610.1 сая төгрөг төсөл, сангийн үлдэгдэл байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл төрийн сангийн харилцах 780,317.8 сая, бусад төсөл, нөөцийн харилцах 242,272.0 сая төгрөгөөр тус тус өссөн нь ирээдүйн өв сангийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого 875,669.3 сая, Монгол Улсын хөгжлийн банк ХХК-ийн Монголбанк дахь мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө 243,124.3 сая төгрөгөөр нэмэгдсэнээс голлон шалтгаалсан байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 1,474,542.7 сая төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах, 386,958.3 сая төгрөг арилжааны банкны харилцах, 570,650.7 сая төгрөг Монголбанк дахь харилцах, 256,778.5 сая төгрөг бусад төсөл, нөөцийн харилцах дансанд тус тус байршиж байна.

Замд яваа мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд Монгол Улсын хөгжлийн банк ХХК-ийн банк хоорондын шилжүүлэг 346.2 сая, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХК-ийн төрийн санд төвлөрүүлсэн 22,104.6 сая төгрөгийн Эрдэнэс таван толгой ХК-ийн ногдол ашиг байна.

Хадгаламжийн үлдэгдэл Монгол Улсын Хөгжлийн банк ХХК-ийн дотоодын банкнүүдэд байршуулсан хадгаламж 130,009.9 сая, Төрийн банк ХХК-ийн Монголбанк дахь хадгаламж 55,013.5 сая, нийт 185,023.4 сая төгрөгөөр буурсан байна.

Аудитын илрүүлэлт:

И-баримтгүй болон анхан шатны баримтын бүрдэл дутуу нийт 472.6 сая, кассын тайлан бэлтгээгүй, бэлнээр зарцуулсан 4.2 сая, төсвийг үр ашиггүй зарцуулсан нийт 34.7 сая төгрөгийн дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

- И-баримтгүй болон зөрүүтэй дүнтэй ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгасан. /Хан-Уул 0.9 сая, Чингэлтэй 3.7 сая, Баянгол 22.5 сая, Налайх 9.6 сая, Багануур 0.8 сая, Сүхбаатар дүүргийн татварын хэлтэс 10.8 сая, Дорнод аймаг дахь гаалийн газар 31.9 сая, Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл 5.7 сая, Монгол улсад засаглалыг бэхжүүлэх төсөл 26.9 сая, Төсөв санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төсөл 266.3 сая, Хөгжлийн хөтөч-дэд бүтэц төсөл 49.1 сая, Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл 7.2 сая, Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төсөл 21.1 сая төгрөг/;

- Анхан шатны баримтын бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн. /Баянгол 15.7 сая, Багануур дүүргийн татварын хэлтэс 0.4 сая төгрөг/;
- Ховд аймгийн Татварын хэлтэс нь бэлнээр авч зарцуулсан 4.2 сая төгрөгийг кассын тайланд бүртгээгүй, тооллого хийгээгүй байна.
- Төсвийг үр ашиггүй зарцуулсан. /Дархан-Уул аймаг дахь гаалийн газар 8.1 сая, Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төсөл 17.3 сая, Төлбөрийн системийн шинэчлэл төсөл 9.3 сая төгрөг/;

3.5.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалт дансны эцсийн үлдэгдэл 887,904.5 сая төгрөг болж, өмнөх оноос 159,799.4 сая төгрөг буюу 21.9 хувиар өссөн байна.

Хүснэгт №2 Богино хугацаат хөрөнгө оруулалт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Үнэт цаас	728,105.1	887,904.5	159,799.4
Дүн	728,105.1	887,904.5	159,799.4

Эх сурвалж: Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат хөрөнгө оруулалт өссөн нь Төрийн банк ХХК 3 хүртэлх сарын хугацаатай 159,799.4 сая төгрөгийн Монголбанкны үнэт цаас худалдан авсантай холбоотой байна.

3.5.3 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 1,385,233.7 сая төгрөг болж, өмнөх оноос 282,897.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №3 Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	64.2	72.3	8.1
Төлбөртэй үйлчилгээний авлага	12,068.6	2,180.1	(9,888.5)
Татаас, санхүүжилтийн авлага	13,472.4	288.0	(13,184.4)
Зээлийн хүүгийн авлага	196,950.1	399,046.7	202,096.6
Дансны авлага /ТӨҮГ/	800,807.5	55,852.3	(744,955.2)
Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	25,206.7	21,320.1	(3,886.6)
Байгууллагаас авах авлага	275,574.4	382,138.5	106,564.1
Хувь хүмүүсээс авах авлага	760.3	1,710.4	950.1
Зээлийн авлага	343,227.1	522,625.3	179,398.2
Дүн	1,668,131.3	1,385,233.7	-282,897.6

Эх сурвалж: Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын дансны үлдэгдлийн 218,631.6 сая төгрөг төсөвт байгууллагын, 989,357.4 сая төгрөг төрийн өмчит байгууллагын, 177,244.7 сая төгрөг нь төсөл, сангийн үлдэгдэл байна.

Авлагын дансны үлдэгдлийн 64.3 хувь буюу 891,326.2 сая төгрөгийг Монгол Улсын Хөгжлийн банк ХХК, 10.5 хувь буюу 144,990.6 сая төгрөгийг Ирээдүйн өв сан, 8.8 хувь буюу 122,457.8 сая төгрөгийг Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах зээлийн 2 дахь шатны төслийн авлага эзэлж байна.

Авлагын дансны үлдэгдлийн бууралтад дараах байгууллагуудын авлага голлон нөлөөлжээ. Тухайлбал:

- Монгол Улсын Хөгжлийн банк ХХК нь дотоодын арилжааны банканд байршуулсан 320,075.4 сая төгрөгийн хадгаламжаа татсан;
- Сангийн сайдын 2020 оны 247 дугаар тушаалаар Бичил санхүүгийн хөгжлийн санг татан буулгаснаас зээлдэгчдэд олгосон зээл, зээлийн хүүгийн авлагаас 4,035.0 сая төгрөгийг төрийн санд шилжүүлсэн;

- Зээлийн батлан даалтын сангийн зээлийн ашиглалт 11,229.9 сая төгрөг буцаан төлөгдсөн;
- Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах зээлийн 2 дахь шатны төслийн 412 аж ахуй нэгж байгууллагаас 20,161.3 сая төгрөгийн зээлийн эргэн төлөлт хийгдсэнээс 24 аж ахуй нэгжид 12,632.1 сая төгрөгийг олгож, дамжуулан зээлийн авлага 7,529.2 сая төгрөгөөр буурсан байна.

Тайлант онд байгууллагаас авах авлага 106,564.1 сая, зээлийн болон зээлийн хүүгийн авлага 921,672.0 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

ААН, иргэдэд олгосон дараах байгууллагуудын нийт 921,672.0 сая төгрөгийн зээл, зээлийн хүүгийн авлага байна. Үүнд:

- Дамжуулан зээлийн авлагатай холбоотой Хөдөө, аж ахуй, хөдөөгийн хөгжил, нэмэлт санхүүжилтийн төсөл 93,572.6 сая, хүүгийн авлага 220.8 сая, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах зээлийн 2 дахь шатны төслийн авлага 121,129.9 сая, хүүгийн авлага 336.5 сая, нийт 215,259.8 сая төгрөг;
- Монгол Улсын Хөгжлийн банк ХХК-ийн зээлийн авлага 268,237.3 сая, зээлийн хүүгийн авлага 398,435.9 сая, нийт 666,673.2 сая төгрөг;
- Төрийн банк ХХК-ийн зээлийн авлага 39,685.5 сая, Хадгаламж даатгалын корпорацийн хүүгийн авлага 53.5 сая, нийт 39,739.0 сая төгрөг.

Аудитын илрүүлэлт:

Авлагын үлдэгдэлд он удаан жил болсон 54.7 сая төгрөгийн дараах авлага байна. Үүнд:

- Сангийн яамнаас авах 2013-2014 онд үүссэн 2.3 сая төгрөгийн авлага. /Хан-Уул дүүргийн татварын хэлтэс 1.1 сая, Увс 0.6 сая, Хэнтий 0.6 сая, бусад 5 аймгийн татварын хэлтэс 31.1 мянган төгрөг/;
- Дампуурсан арилжааны банкнуудтай холбоотой 11.9 сая төгрөгийн авлага. /Нийслэлийн татварын хэлтэс Сэргээн босголт банк 9.8 сая, Сонгинохайрхан дүүргийн татварын хэлтэс Сэргээн болголт банк 0.7 сая, Хөвсгөл аймгийн татварын хэлтэс Сэргээн босголт банк 1.4 сая төгрөг/;
- Ажлаас чөлөөлөгдсөн ажилчидтай холбоотой 2.9 сая төгрөгийн авлагын үлдэгдэл байна. /Нийслэл 0.5 сая, Багахангай 0.2 сая, Баянзүрх дүүргийн татварын хэлтэс 2.2 сая төгрөг/.
- Завхан аймаг дахь Арцсуурь гаалийн хороонд 2013-2015 онуудад үүссэн 9.6 сая төгрөгийн гэрэл цахилгааны төлбөрийн авлага;
- Гаалийн ерөнхий газарт 2009 оноос өмнө үүссэн 24.5 сая төгрөгийн авлага нь харилцагч байгууллагуудын мэдээлэл Улсын бүртгэлийн ерөнхий газар болон Татварын ерөнхий газрын мэдээллийн санд байхгүй тул шийдвэрлэх боломжгүй болсон;
- Сэлэнгэ аймаг дахь гаалийн газарт 2000 оноос өмнө үүссэн харилцагч нь нас барсан шалтгаантай шийдвэрлэх боломжгүй болсон нийт 2.6 сая төгрөгийн орон сууцны ашиглалтын төлбөрийн авлага байна.

3.5.4 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 527,312.6 сая төгрөг болж, өмнөх оноос 422,604.6 сая төгрөг буюу 1.2 дахин өссөн байна.

Хүснэгт №.4 Урьдчилгаа дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	85,283.3	522,479.2	437,195.9
Урьдчилгаа тооцоо	19,424.7	4,833.4	-14,591.3
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	16,304.1	19.2	-16,284.9
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	3,120.6	4,814.2	1,693.6
Дүн	104,708.0	527,312.6	422,604.6

Эх сурвалж: Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэл 437,195.9 сая төгрөгөөр өссөн нь гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа 30 төсөл, арга хэмжээний 458,671.7 сая төгрөгийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийн урьдчилгаа төлбөрийг бүртгэснээс шалтгаалсан байна. Үүнд:

- Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төслийн 209,775.2 сая;
- Онцгой байдлын байгууллагад агаараас аврах ажиллагаа явуулах нэгж байгуулах, нисдэг тэрэг, гал унтраах автомашин нийлүүлэх төслийн 97,281.0 сая;
- Эрдэнэт хотын хатуу хог хаягдлыг боловсруулах байгууламжийг барих төслийн 24,726.7 сая;
- Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээвэр нэвтрүүлэх төслийн 22,677.9 сая;
- Ерөнхий боловсролын сургууль барих төслийн 19,132.4 сая
- Хөдөлмөр эрхлэлтийн ур чадварыг дээшлүүлэх төслийн 18,315.6 сая;
- Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх, засвар арчлалтын төслийн хөрөнгө оруулалтын ажлын 13,616.6 сая
- Бусад 27 төсөл хөтөлбөрийн 53,146.3 сая төгрөг байна.

3.5.5 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 9,831.6 сая, эцсийн үлдэгдэл 11,091.8 сая төгрөг болж, 1,260.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 6 Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	77.2	69.1	-8.1
Бэлэн бүтээгдэхүүн	890.3	1,716.8	826.5
Бичиг хэргийн материал	3,285.9	3,247.0	-38.9
Аж ахуйн материал	3,819.8	2,917.0	-902.8
Сэлбэг хэрэгсэл	73.7	119.1	45.4
Түлш, шатах тослох материал	141.6	183.2	41.6
Барилгын засварын материал	32.1	72.0	39.9
Хүнсний материал	20.5	25.7	5.2
Бусад хангамжийн материал	1,341.7	2,600.7	1,259.0
Мал амьтад	148.8	141.2	-7.6
Дүн	9,831.6	11,091.8	1,260.2

Эх сурвалж: Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд бараа материал худалдан авсан 12,835.7 сая, шилжүүлэн авсан 1,147.6 сая, хандиваар 270.4 сая, бусад 1,863.3 сая, нийт 16,117.0 сая төгрөгөөр нэмэгдэж, 10,521.1 сая төгрөгийн бараа материалыг зарцуулж, балансаас балансад шилжүүлсэн 3,716.0 сая, бусад 619.7 сая, нийт 14,856.8 сая төгрөгөөр хасагдсан байна.

Тайлант онд бэлэн бүтээгдэхүүн 826.5 сая, бусад хангамжийн материал 1,259.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь гаалийн шинэчлэл төслийн хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан барилгуудад ашиглагдах хангамжийн материал, лабораторийн шинжилгээний тоног төхөөрөмжүүдийн урвалж, дээж бодисуудыг худалдан авснаас шалтгаалсан байна.

3.5.6 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 1,405,428.6 сая төгрөг болж, өмнөх оноос 431,912.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №6 Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт+/Бууралт-
Бусад санхүүгийн хөрөнгө /ТӨҮГ/	443,132.0	184,500.0	-258,632.0
Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	1,309,196.0	1,135,915.4	-173,280.6
БЗЭБуй эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	85,013.2	85,013.2	-
Дүн	1,837,341.2	1,405,428.6	-431,912.6

Эх сурвалж: Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бусад эргэлтийн хөрөнгө 431,912.6 сая төгрөгөөр буурсан нь Хадгаламж даатгалын корпорац Монголбанкны 262,845.0 сая төгрөгийн богино хугацаат үнэт цаасыг хоёрдогч зах зээлд борлуулснаас голлон шалтгаалжээ.

Бусад эргэлтийн хөрөнгө дансанд гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа 29 төсөл, арга хэмжээний зардлыг хуримтлуулж бүртгэсэн 1,067,635.9 сая төгрөгийн дараах ТХН-ийн зам гүүр, барилга байгууламж, тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээний ажлууд байна. Тухайлбал:

- Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн 270,602.2 сая;
- Орон сууцны хороолол, дэд бүтэц төсөл 172,624.7 сая;
- Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замыг хөгжүүлэх 1, 2 дахь шатны төслийн 172,461.0 сая;
- Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх, засвар арчлалтын төслийн 89,091.2 сая;
- Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах, хийн хоолой байгуулах төслийн нарийвчилсан техник эдийн засгийн үнэлгээ боловсруулах төслийн 57,934.6 сая;
- Хилийн боомтын дэд бүтэц төслийн 52,324.9 сая;
- Улиастай Тосонцэнгэл чиглэлийн 67.0 км хатуу хучилттай авто зам барих төслийн 43,122.4 сая;
- Тайшир-Алтай ус хангамж төслийн 38,792.9 сая;
- Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төсөл 31,594.9 сая;
- Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төсөл-II 32,989.8 сая төгрөгийн үлдэгдэл байна,

Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн хөрөнгийн 99.9 хувь буюу 85,000.0 сая төгрөг нь Хадгаламжийн даатгалын корпорацийн 2013 онд худалдан авсан Төрийн банкны хувьцаа байна.

3.5.7 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалтын эхний үлдэгдэл 4,568,783.9 сая, эцсийн үлдэгдэл 4,935,292.4 сая төгрөг болж, 366,508.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт+/Бууралт-
Урт хугацаат хадгаламж	60,117.0	490,969.3	430,852.3
Үнэт цаас	424,942.0	522,716.2	97,774.2
Урт хугацаат зээл	4,083,724.9	3,921,606.9	-162,118.0
Дүн	4,568,783.9	4,935,292.4	366,508.5

Эх сурвалж: Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урт хугацаат хөрөнгө оруулалт дансны үлдэгдлийн 55.4 хувь буюу 2,735,370.5 сая төгрөг Монгол Улсын Хөгжлийн банк ХХК-ийн, 43.2 хувь буюу 2,134,089.1 сая төгрөг Төрийн банк ХХК-ийн, 1.4 хувь буюу 65,832.9 сая төгрөг нь бусад байгууллагын үлдэгдэл байна.

Урт хугацаат хөрөнгө оруулалтын дансны үлдэгдэл өссөн нь Монгол Улсын Хөгжлийн банк ХХК-ийн урт хугацаат хадгаламж 428,674.3 сая, Төрийн банк ХХК-ийн үнэт цаас 142,172.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Урт хугацаат хөрөнгө оруулалтын дансанд харьяа ТӨХК болон ХК-уудын хадгаламж, үнэт цаас, зээлийн 4,935,292.4 сая төгрөгийн дараах үлдэгдэл байна. Үүнд:

- Монгол Улсын Хөгжлийн банк ХХК-ийн урт хугацаат 2,170,253.7 сая төгрөгийн зээлээс ТӨААН-үүдэд олгосон 773,092.8 сая, хувийн хэвшлийн ААН-үүдэд олгосон 1,397,160.9 сая, үнэт цаас 103,020.4 сая, урт хугацаат хадгаламж 438,967.1 сая, хөрөнгө оруулалт 23,129.2 сая, нийт 2,735,370.4 сая төгрөг;
- Төрийн банк ХХК-ийн урт хугацаат 1,714,393.4 сая төгрөгийн зээлээс иргэдэд олгосон 1,516,402.2 сая, ТӨААН-үүдэд олгосон 246.8 сая, хувийн хэвшлийн ААН-үүдэд олгосон зээл 197,744.3 сая, мөн үнэт цаас 419,695.7 сая, нийт 2,134,089.1 сая төгрөг;
- Үндэсний давхар даатгал ХК-ийн 52,002.1 сая
- Сангийн яамны хөрөнгө оруулалт 13,830.8 сая төгрөг байна.

3.5.8 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 936,865.7 сая төгрөг болж, өмнөх оноос 34,350.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 7 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-) /сая төгрөг/
Биет хөрөнгө	810,413.6	754,962.6	-55,451.0
Барилга, байгууламж, орон сууц	193,063.4	230,506.9	37,443.5
Авто-тээврийн хэрэгсэл	25,539.3	29,147.8	3,608.5
Машин тоног төхөөрөмж(компьютер)	116,340.7	163,797.6	47,456.9
Тавилга, аж ахуйн эд хогшил	39,064.7	48,762.1	9,697.4
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	7.3	7.3	-
Бусад үндсэн хөрөнгө	16,506.3	18,950.9	2,444.6
Дуусаагүй барилга, байгууламж	419,844.6	263,723.0	-156,121.6
Ном	47.3	67.0	19.7
Биет бус хөрөнгө	41,806.6	52,168.6	10,362.0
Программ хангамж	18,864.2	21,692.1	2,827.9
Бусад биет бус хөрөнгө	22,942.4	30,476.5	7,534.1
Бусад хөрөнгө /ТӨҮГ/	118,996.0	129,734.5	10,738.5
Хойшлогдсон татварын хөрөнгө /ТӨҮГ/	21,219.7	17,646.3	-3,573.4
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө /ТӨҮГ/	97,776.3	97,819.4	43.1
Бусад эргэлтийн бус хөрөнгө /ТӨҮГ/ + бусад		14,268.8	14,268.8
Дүн	971,216.2	936,865.7	-34,350.5

Эх сурвалж: Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 7,253.9 сая, үнэ төлбөргүй авсан 5,685.5 сая, балансаас баланст шилжүүлэн авсан 63,981.7 сая, дахин үнэлсэн 19.1 сая, бусад 191,791.6 сая, нийт 268,731.9 сая төгрөгөөр нэмэгдэж, холбогдох тогтоол шийдвэрийн дагуу акталсан 7,217.5 сая, балансаас баланст шилжүүлсэн хөрөнгө 285,767.7 сая, дахин үнэлгээний хорогдол 55.8 сая, бусад 10,041.4 сая, нийт 303,082.4 сая төгрөгөөр хасагдсан байна.

Машин тоног төхөөрөмж 47,456.9 сая, барилга байгууламж, орон сууц 37,443.5 сая, тавилга эд хогшил 9,697.4 сая төгрөгөөр тус тус өмнөх оноос өссөн байна.

Дээрх өсөлт нь гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл хөтөлбөрөөс 26,318.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг үнэ төлбөргүй хүлээн авсан мөн 21 төсөвт байгууллагын улсын төсвийн хөрөнгө оруулалт, их засвар ажил 35,233.5 сая, Төрийн банк

ХХК-ийн 2,391.5 сая төгрөгийн шинээр баригдсан барилга байгууламж зэргээс нөлөөлсөн байна.

Дуусаагүй барилгад бүртгэлтэй 263,723.0 сая төгрөгөөс гадаад зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа 6 төсөл, арга хэмжээний 256,074.2 сая төгрөгийн барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний ажлын дараах үлдэгдэл байна. Үүнд:

- Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын шинэчлэл төсөл 100,375.2 сая;
- Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр 4 төсөл 82,909.7 сая;
- Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөл төсөл 25,932.0 сая;
- Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах төсөл 24,518.1 сая;
- Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төсөл 21,964.7 сая төгрөг;
- Улаанбаатар хотын төлбөрийн чадварт нийцсэн орон сууц ба хотын дахин төлөвлөлтийн төсөл 374.5 сая төгрөг байна.

Бусад хөрөнгө дансанд Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-ийн 10.0 сая, Монгол Улсын хөгжлийн банк ХХК-ийн 17,631.5 сая, Монголын үнэт цаасны клирингийн төв ХХК-ийн 4.7 сая, нийт 17,646.2 сая төгрөгийн хойшлогдсон татварын хөрөнгө мөн Монгол Улсын хөгжлийн банканд 97,819.4 сая, Төрийн банканд 14,268.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

Их засварын зардлыг капиталжуулаагүй, жилийн эцсийн тооллогыг хангалтгүй зохион байгуулсан, ашиглах боломжгүй хөрөнгийг данс бүртгэлээс хасаж шийдвэрлээгүй, хандиваар ирсэн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй зэрэг нийт 756.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Их засварын зардлыг капиталжуулж бүртгээгүй. /Төв аймгийн татварын хэлтэс 113.3 сая, Завхан аймгийн татварын хэлтэс 51.4 сая төгрөг/;
- Хөрөнгийн тооллого хийгээгүй, ашиглах боломжгүй хөрөнгийг данс бүртгэлээс хасаж шийдвэрлээгүй. /Төв аймаг татварын хэлтэс 575.6 сая, Сонгино хайрхан дүүргийн татварын хэлтэс 16.0 сая төгрөг/;
- Сүхбаатар аймгийн Бичигт дэх гаалийн газар БНХАУ-ын талаас 2016 оны 9 сард уурын зуух үнэ төлбөргүй барьж өгсөн боловч данс бүртгэлд тусгаагүй байна.

3.5.9 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 6,872,011.3 сая, эцсийн үлдэгдэл 7,080,724.0 сая төгрөг болж, 208,712.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 9. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт+/ Бууралт-
Богино хугацаат өр төлбөр:	1,470,582.7	1,423,873.3	-46,709.4
Богино хугацаат үнэт цаас	-	-	-
Богино хугацаат зээлийн өглөг	1,256,833.8	1,156,857.3	-99,976.5
Ажилчидтай холбогдсон өглөг	379.3	134.1	-245.2
Бараа үйлчилгээний зардлын өглөг	3,141.3	1,116.0	-2,025.3
Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг	67.8	-	-67.8
Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	2,951.6	4,111.9	1,160.3
Зээлийн хүүгийн өглөг	38,442.4	31,207.5	-7,234.9
Бусад өглөг	109,479.9	183,526.7	74,046.8
Урьдчилж орсон орлого	59,286.6	46,919.8	-12,366.8
Урт хугацаат өр төлбөр:	5,401,428.6	5,656,850.7	255,422.1
Урт хугацаат үнэт цаас	2,173,068.8	2,394,367.0	221,298.2
Урт хугацаат зээл	3,228,359.8	3,262,483.7	34,123.9
Дүн	6,872,011.3	7,080,724.0	208,712.7

Эх сурвалж: Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд урт хугацаат өр төлбөр 255,422.1 сая төгрөгөөр нэмэгдсэн бол богино хугацаат өр төлбөр 46,709.4 сая төгрөгөөр буурчээ.

Богино хугацаат зээлийн өглөг өмнөх оноос 9.2 хувиар буурч, 1,156,857.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнд:

- Төрийн банк ХХК-д иргэд ААНБ-уудын харилцах данс 812,879.9 сая, хугацаагүй хадгаламж, банк санхүүгийн байгууллагуудын харилцахын үлдэгдэл 274,395.4 сая, нийт 1,087,275.3 сая төгрөг;
- Монгол Улсын Хөгжлийн банк ХХК-д дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагуудын байршуулсан хадгаламж 69,216.4 сая;
- Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн ААНБ-уудын дамжуулан зээлийн өглөг 365.6 сая төгрөг байна.

Урт хугацаат үнэт цаас 221,298.2 сая төгрөгөөр өссөн нь Төрийн банк ХХК тайлант онд Засгийн газрын үнэт цаасыг барьцаалан буцаан худалдан авах нөхцөлтэй нэг жилийн хугацаатай гэрээ байгуулж, Нидерланд Улсын ЭФ Си Си Секюритиз Би Ви банкнаас 71,242.4 сая төгрөгийн ам.доллар худалдан авсан, мөн Монгол Улсын Хөгжлийн банкны дотоод, гадаадын зах зээлд гаргасан бондын 150,055.8 сая төгрөгийн тайлант оны ханшийн алдагдал нөлөөлсөн байна.

Урт хугацаат зээл 34,123.9 сая төгрөгөөр нэмэгдэж, харьяа байгууллагуудын 3,262,483.7 сая төгрөгийн өр төлбөр бүртгэлтэй байна. Тухайлбал:

- Монгол Улсын Хөгжлийн банк ХХК-ийн БНХАУ-ын Хөгжлийн банк, Жэй Пи Морган Чэйс Банк, Внэшэконом банк зэрэг гадаадын арилжааны банкнаас авсан зээл нийт 713,379.1 сая;
- Төрийн банк ХХК-ийн урт хугацаат өр төлбөр 1,957,502.0 сая;
- Хадгаламжийн даатгалын корпорац нь Төрийн банк ХХК-ийн хувьцаа худалдан авах, зорилгоор авсан зээл 149,001.2 сая;
- Үндэсний давхар даатгал ХК Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд заасны дагуу байгуулсан хамтын эрсдэлийн сангийн 1,927.1 сая, эрсдэлээс хамгаалах сангийн 4,453.6 сая, нийт 6,380.7 сая төгрөгийн ажил гүйлгээг тус тус бүртгэсэн байна.

Мөн гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн 436,115.8 сая төгрөгийн урт хугацаат дамжуулан зээлийн үлдэгдэл байна. Үүнд:

- Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах II дахь шатны төслийн 204,116.4 сая;
- Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах төслийн 39,547.1 сая;
- Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил Нэмэлт санхүүжилт төслийн 92,077.1 сая;
- Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын шинэчлэл төслийн 100,375.2 сая төгрөг байна.

Аудитын илрүүлэлт:

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 3,212.0 сая төгрөгийн барьцаа, хугацаа хэтэрсэн 24.4 сая төгрөгийн өр байна. Үүнд:

- Горхи мэлхий хад амралтын газарт 2011 онд Нийслэлийн татварын газраас шалгалт хийж, 22.9 сая төгрөгийн нэмэгдсэн өртгийн албан татварыг нөхөн төлөх акт тогтоосон боловч төлөгдөөгүй.
- Өглөг бүртгэлтэй харилцагч байгууллагуудын мэдээлэл Улсын бүртгэлийн ерөнхий газар болон Татварын ерөнхий газрын мэдээллийн санд байхгүй, шийдвэрлэх боломжгүй 1.5 сая төгрөгийн өглөг тус тус бүртгэлтэй байна.

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 4,653,054.7 сая, эцсийн үлдэгдэл 5,610,636.3 сая төгрөг болж, 957,581.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №9 Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/
			Өсөлт/+, бууралт /-/
Засгийн газрын оруулсан капитал	105,127.8	97,211.6	-7,916.2
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	1,362,382.1	1,357,200.3	-5,181.8

Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/	43,130.6	47,630.6	4,500.0
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	106,456.8	112,674.9	6,218.1
Нийт өмчийн дүн	1,617,097.3	1,614,717.4	-2,379.9
Хуримтлагдсан үр дүн	2,956,398.1	3,912,816.7	956,418.6
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	59,907.9	60,238.3	330.4
Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	651.4	3,863.9	3,212.5
Нөөцийн сан	19,000.0	19,000.0	-
Дүн	4,653,054.7	5,610,636.3	957,581.6

Эх сурвалж: Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны өсөлт нь тайлант үеийн үр дүн 1,202,272.8 сая төгрөгөөр нэмэгдсэнээс голлон нөлөөлсөн байна.

Засгийн газрын оруулсан капитал 7,916.2 сая төгрөгөөр буурахад дараах байгууллагуудад гарсан материаллаг хэмжээний өөрчлөлт голлон нөлөөлсөн байна. Тухайлбал:

- Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК 1,000.0 сая ;
- Зээлийн батлан даалтын санг ХХААХҮЯ-д шилжүүлснээс 7,800.0 сая;
- Бүс нутгийн ложистикийн төвийг хөгжүүлэх төслийн санхүүгийн тайлангийн хаалтын тайлан гаргасан холбоотой 3.9 сая төгрөг.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд зааснаар тайлант онд 8,477,023.3 сая төгрөгийн орлого улсын төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 8,070,255.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 95.2 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 1. Төвлөрүүлэх орлого

Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Нийт төвлөрүүлэх орлого	8,477,023.4	8,070,255.9	406,767.5	95.2
Татварын ерөнхий газар	4,258,824.6	3,920,782.8	338,041.8	92.1
Үүнээс: Төсвийн тогтворжуулалтын санд	55,151.2	66,242.9	-11,091.7	120.1
Ирээдүйн өв санд	758,205.0	753,878.6	4,326.4	99.4
Гаалийн ерөнхий газар	3,024,642.4	2,891,865.0	132,777.4	95.6
Сангийн яам	87,900.0	136,456.4	-48,556.4	155.2
Гадаад эх үүсвэрээс олгосон зээлийн эргэн төлөлт	142,000.0	139,424.5	2,575.5	98.0
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	150,300.2	161,605.7	-11,305.5	107.5

Цар тахлын улмаас эдийн засгийн өсөлт саарснаар ААНОАТ 343,500.0 сая төгрөгөөр, гадаад худалдааны эргэлт буурснаар гаалийн ерөнхий газрын төвлөрүүлэх орлого 132,777.4 сая төгрөгөөр тус тус тасарсан нь нийт орлогын төлөвлөгөө 406,767.5 тэрбум төгрөгөөр тасрахад гол нөлөө үзүүлсэн байна.

Төсвийн төлөвлөлт

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрт зориулан 2,676,762.9 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,735,682.2 сая төгрөгийг урсгал зардалд, 930,932.4 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 10,148.3 сая төгрөгийг дотоод эх үүсвэрээс олгох зээлд зарцуулахаар батлагджээ.

Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр¹ нийт санхүүжилтийг 423,530.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 3,100,293.5 сая төгрөгөөр баталж,

¹ Төсвийн тодотгол 2020 оны төсвийн тухай хуульд 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан.

1,923,464.8 сая төгрөгийг урсгал зардалд, 1,166,391.8 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 10,436.9 сая төгрөгийг дотоод эх үүсвэрээс олгох зээлд зарцуулахаар тусгасан байна.

Нийт зардлын 1,680,170.9 сая төгрөгийг улсын төсвөөс, 1,472,860.0 сая төгрөгийг гадаад зээл, 150,300.2 сая төгрөгийг тусламжийн эх үүсвэрээс, 5,426.6 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр, төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх төлбөрийг 208,464.2 сая төгрөгөөр тус тус төлөвлөжээ.

Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,553,027.8 сая төгрөгийг санхүүжүүлж 127,143.1 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон, тусламжийн санхүүжилтээс 161,594.5 сая, төсөв болон дамжуулан зээлээс эргэж төлөгдөх төлбөрөөс 172,830.3 сая төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 11,825.0 сая төгрөгийг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 7,904.5 сая төгрөгөөр давсан нь төсөл, хөтөлбөрүүдийн дамжуулан зээлийн авлагыг үндсэн үйл ажиллагааны орлогоор тооцсонтой холбоотой байна.

Туслах үйл ажиллагааны орлого 1,930.4 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 424.2 сая төгрөгөөр давсан нь төсөл, хөтөлбөрүүдийн арилжааны банканд байршиж байгаа харилцахын хүүгийн орлогыг туслах үйл ажиллагааны орлогоор бүртгэсэн нь нөлөөлсөн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,828,126.6 сая төгрөг буюу 91.2 хувьтай байна. Батлагдсан төсөвт зардал бүлгийн дүнгээр хэтрээгүй боловч эдийн засгийн ангиллаар материаллаг дүнтэй зарцуулагдаагүй дараах үлдэгдлүүд байна. Үүнд:

- Цалин, НДШ, ашиглалтын зардал, хангамжийн материал, норматив зардал, эд хогшил урсгал засвар, томилолтын зардлуудыг 13,097.8 сая төгрөгөөр дутуу зарцуулсан нь Хөшгийн хөндий дэх олон улсын нисэх онгоцны буудал ашиглалтад ороогүйгээс 99 орон тоо, гаалийн шинэчлэлийн 43 орон тоог нэмж шийдвэрлэсэн боловч цар тахлаас шалтгаалан салбар лабораториудын тоног төхөөрөмж сонгон шалгаруулалт болон нийлүүлэлтийн хугацаа хойшлогдсоноос төсөв зарцуулагдаагүй;
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж болон бараа үйлчилгээний бусад зардал бүлгийн дүнгээр 32,498.6 сая төгрөгөөр дутуу зарцуулсан нь Ковид-19 цар тахалтай холбогдуулан Засгийн газраас гаргасан шийдвэрийн дагуу төсөл, хөтөлбөрүүдийн зөвлөх үйлчилгээ болон бусад төлбөр, зарим зардлын санхүүжилтийг хойшлуулсан;
- Гадаад зээлийн үйлчилгээний төлбөрийг 39,756.5 сая төгрөгөөр дутуу зарцуулсан нь тухайн жилийн үйл ажиллагаа, валютын ханшийн өөрчлөлт нөлөөлсөн;
- Татаас 36,589.6 сая төгрөгөөр зарцуулагдаагүй үлдсэн нь хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас санхүүжилтийг олгоогүй;
- Урсгал шилжүүлгийг бүлгийн дүнгээр 10,385.8 сая төгрөгөөр дутуу зарцуулсан нь өндөр насны тэтгэвэрт гарах эрх нь үүссэн 41 албан хаагч тэтгэвэрт гараагүйгээс тэтгэмжийг олгоогүй, Сангийн яам 2,320.1 сая төгрөгийн олон улсын байгууллагын гишүүнчлэлийн төлбөрийн гүйцэтгэл бага гарсан, орон нутгийн хөгжлийн сангаас олгох 6,600.0 сая төгрөгийн урсгал шилжүүлгийн зардал зарцуулагдаагүй зэрэг нь голлон нөлөөлсөн байна.

Хөрөнгө оруулалтын 11 төсөл, арга хэмжээнд 1,166,391.8 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 1,049,187.7 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон бөгөөд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 253 дугаар тогтоолоор улсын төсвийн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл нь гараагүй Татварын ерөнхий газрын 1,085.0 сая, Хөгжлийн хөтөч дэд бүтэц төслийн 140.3 сая, нийт 1,225.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг барьцаа дансанд байршуулан авч үлдсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Төрийн болон орон нутгийн өмчит бус хуулийн этгээдээс хандив тусламжаар авсан 38.9 сая, орон нутгийн төсвийн захирагчдаас 3,154.4 сая, дээд шатны төсвийн захирагчаас 871.4 сая, төсвийн байгууллагын нэмэлт үйл ажиллагааны орлого 147.2 сая, нийт 4,211.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

Үүнээс бараа ажил үйлчилгээний зардалд 3,425.0 сая, урсгал шилжүүлэгт 297.3 сая, хөрөнгийн зардал 101.9 сая, нийт 3,824.2 сая төгрөгийг зарцуулж, 387.7 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 халдварт цар тахалтай холбогдуулан дараах зардлууд гарсан байна.

- Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зориулан маск, ариутгалын бодис, дархлаа дэмжих бүтээгдэхүүн, халдваргүйжүүлэлтийн зардалд 1,273.7 сая, гаалийн ажилчдын нэмэгдэл цалин, урамшуулал, хилийн боомтуудын албан хаагчдыг зөөвөрлөх автомашины зардалд 1,326.3 сая, нийт 2,600.0 сая төгрөгийг төсвөөс зарцуулсан байна.
- Мөн Ковид-19 цар тахлын эсрэг авч хэрэгжүүлэх хойшлуулшгүй цаг үеийн шинжтэй арга хэмжээний санхүүжилтэд 50,505.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 халдварт цар тахлын улмаас аудит хийх цар хүрээ хязгаарлагдаж, ашиглагдаж байгаа программ хангамж, мэдээлэлтэй биечлэн танилцах, нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх анхан шатны баримт материалуудыг бүрэн хамруулах боломжгүй, цаг хугацааны хязгаарлагдмал байдалд аудитыг цахимаар хийж гүйцэтгэв.

3.8 Аудитын гол асуудал

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн дараах асуудлуудад анхаарал хандуулах шаардлагатай байна. Үүнд:

- Нэгтгэлд хамрагдсан 119 төсөл хөтөлбөрөөс 57 төсөл хөтөлбөрт аудит хийж, аудитаар нийт 463,970.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн нь Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нийт алдаа зөрчлийн 96.8 хувийг эзэлж байна.
- Санхүүгийн тайланд нэгтгэгдсэн 119 төсөл хөтөлбөрөөс 12 Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэн асуудлын хүрээнд хамаарах 42 төсөл хөтөлбөр нь төслийн нэгжгүй, данснууд бүртгэлтэй бөгөөд эдгээр дансаар хийгдсэн ажил гүйлгээний үр дүнд бий болсон хөрөнгийн бүртгэл, тайлагналд тавих хяналт сул байна.
- Нэгтгэлд 6 төслийн санхүүгийн тайланд хаалтын баланс гаргасан боловч санхүүгийн холбогдох баримт материал дутуу, хариуцах албан тушаалтан байхгүйгээс аудитын явцад хүндрэл үүссэн тул төсөл хэрэгжүүлэгчийн нэгжийн удирдах болон санхүүгийн ажилтнуудыг төслийн үйл ажиллагааг зогсоох ажил эцэслэн шийдвэрлэгдэх хүртэл аливаа хариуцлагаас чөлөөлөхгүй байх шаардлагатай байна.
- 2020 онд үйл ажиллагаа нь зогсож хаагдсан 6 төслөөс Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл 1-ийг хэрэгжүүлэх гэрээний хугацааг сунгах хүсэлтийг Сангийн сайдаас 2019 оны 10/1698 тоот албан бичгээр Азийн хөгжлийн банканд хүргүүлсэн боловч тусгай замын бүтээн

байгуулалттай холбоотой газар чөлөөлөх үйл явц удааширсан тул Азийн хөгжлийн банкнаас уг төслийг сунгах боломжгүй гэж үзэн хаах шийдвэр гаргасан байна. Цаашид гадаад зээл, тусламжийн эх үүсвэрээр хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдийн үр ашиг, үр дүнд анхаарч, төсөл хөтөлбөрийн үйл ажиллагаа, санхүүгийн үр өгөөжид тавих дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

3.9 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 65 байгууллага шилэн дансны цахим хуудсанд 1,898 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 703 мэдээллийг байршуулаагүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 130,637.8 сая төгрөгийн 4 зөвлөмж өгснөөс 3 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, харьяа байгууллагууд болон төсөл, хөтөлбөрийн дамжуулан зээлийн авлага, өр төлбөрийг санхүүгийн тайланд бүртгэх, тооцоо нийлж баталгаажуулах талаар өгсөн зөвлөмж бүрэн хэрэгжээгүй, нийт зөвлөмжийн хэрэгжилт 87.5 хувьтай байна.

3.11 Хойших үйл явдал ба дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын явцад анхаарал татахуйц, дараагийн аудитаар авч үзэх дараах асуудал ажиглагдлаа. Үүнд:

- Гадаад зээл, тусламжийн эх үүсвэрээр хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт, зээлийн ашиглалт, дамжуулан зээлийн авлагын бүртгэл, тайлагналын талаарх асуудлыг дараагийн аудитаар нарийвчлан анхаарч үзэх нь зүйтэй гэж үзэж байна.

4. Аудитын илрүүлэлт

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 188 байгууллага, нэгжийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс Зөрчилгүй 106, Хязгаарлалттай 6 /төсөвт байгууллага 1, төсөл хэрэгжүүлэгч нэгж 5/, итгэл үзүүлсэн 5, түүвэрт хамрагдсан 71 тайлан байна.

4.1 Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа, зөрчил

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 479,440.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 317,465.6 сая төгрөгийн 188 алдааг аудитын явцад залруулж, 174.3 сая төгрөгийн зөрчилд 14 төлбөрийн акт тогтоож, 158,152.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах 92 албан шаардлага хүргүүлж, 3,648.9 сая төгрөгийн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх 162 зөвлөмж өгсөн.

4.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитаар илэрсэн алдаа, зөрчил

Аудитаар нийт 426,410.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 328,823.2 сая төгрөгийн алдааг залруулж, 2 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 97,586.9 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн 328,823.2 сая төгрөгийн алдааг санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулга хийсэн. Үүнд:

- Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлангийн эхний үлдэгдэл өмнөх оны аудит хийсэн тайлангаас нийт 33,897.6 сая төгрөгөөр илүү нэгтгэсэн;
- Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайланд авлагыг 0.8 сая, бараа материалыг 116.7 сая, бусад эргэлтийн хөрөнгийг 1,224.2 сая, урт хугацаат зээлийг 39,549.0 сая, өр төлбөрийг 44,327.3 сая, засгийн газрын оруулсан капитал /төрийн-ТӨҮГ/-ыг 2,915.2 сая төгрөгөөр тус тус илүү, урьдчилгааг 90.1 сая, үндсэн хөрөнгийг 358.8 сая, цэвэр хөрөнгийг 3,885.5 сая, хуримтлагдсан үр дүнг 6,022.5 сая, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүүг 778.2 сая төгрөгөөр тус тус дутуу нэгтгэсэн;
- Санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайланд үйл ажиллагааны орлогыг 16,359.7 сая, татварын бус орлогыг 5,332.7 сая, тусламж санхүүжилтийн орлогыг 11,027.1 сая, үйл ажиллагааны зардлыг 12,063.4 сая, бараа ажил үйлчилгээний зардлыг 8,525.2 сая, хүүгийн зардлыг 9,795.7 сая, үйл ажиллагааны үр дүнг 4,296.4 сая төгрөгөөр тус тус дутуу, урсгал шилжүүлгийн зардлыг 6,257.6 сая, үйл ажиллагааны бус зардлыг 16,249.2 сая төгрөгөөр илүү нэгтгэсэн;
- Нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайланд нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт дансыг 16.7 сая, үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлтийг 17.5 сая, өмчит гарсан өөрчлөлтийг 972.3 сая, тайлант үеийн үр дүнг 17,630.4 сая төгрөгөөр тус тус дутуу нэгтгэсэн;
- Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд татварын бус орлого дансыг 12,451.8 сая, тусламж, санхүүжилтийн орлогыг 3,454.2 сая, бараа үйлчилгээний бусад зардлыг 22.4 сая, урсгал шилжүүлгийн зардлыг 3,730.1 сая, хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээний орлогыг 877.6 сая, хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээний зардлыг 13,209.4 сая төгрөгөөр тус тус илүү, бараа ажил үйлчилгээний зардлыг 169.3 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 113.2 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 62.1 сая, хангамжийн бараа материалын зардлыг 15.9 сая, бусад эх үүсвэрийг 9.9 сая төгрөгөөр тус тус дутуу нэгтгэсэн;
- Нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд нийт зардлын гүйцэтгэлийг 19,738.3 сая төгрөгөөр илүү нэгтгэсэн;
- Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайланд хоорондын тооцоог 39,549.0 сая төгрөгөөр дутуу, нэгтгэсэн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тайланд нийт 26,018.8 сая төгрөгийн давхардсан орлого зардлын ажил гүйлгээг дутуу устгаж нэгтгэсэн байна.

Албан шаардлага

1. Тайлант онд ашиглалт гарсан, гадаад зээлийн эх үүсвэрээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлагын үлдэгдэл нь дамжуулан зээлдэгч байгууллагуудын санхүүгийн тайлангаарх зээлийн өглөгийн үлдэгдлээс 92,235.7 сая төгрөгөөр илүү, 83,445.6 сая төгрөгөөр дутуу бүртгэлтэй бөгөөд өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

Энэ нь Засгийн газрын 2006 оны 185 дугаар тогтоолоор баталсан "Гадаадын зээлийн хөрөнгийг дотоодод дамжуулан зээлдүүлэх журам"-ын 5.6-д "Зээлдэгчийн зээлийн хөрөнгөөр авсан эд хөрөнгө нь төрийн өмчид хамаарах бөгөөд дамжуулан зээлдүүлэх гэрээ дуусгавар болох хүртэл тайлан тэнцэлдээ өглөг хэлбэрээр бүртгэнэ" журмын 5.8-д "Зээлдэгч нь үндсэн болон хүүгийн төлбөр хийсэн тухай бүр Сангийн яаманд албан бичгээр мэдэгдэж улирал бүр тооцоо нийлж баталгаажуулах үүрэгтэй" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дамжуулан зээлдүүлсэн зээлийн үлдэгдлийн тооцоог нийлж, санхүүгийн тайланд зөв бүртгэж, тайлагнах, гадаад зээлийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн зээлийн гэрээг байгуулахдаа тухайн зээллэгийн нөхцөлтэй уялдуулан гэрээний зориулалтыг тодорхой тусгаж, төсөвт аливаа нэмэлт төлбөрийн дарамт учруулахгүй байх зарчмыг баримтлан ажиллах албан шаардлага хүргүүлэв.

2. Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 65 байгууллага шилэн дансны цахим хуудсанд нийт 11,084 мэдээлэл байршуулахаас 105,288.1 сая төгрөгийн 1,898 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, үйлчилгээ болон цалингийн зардлаас бусад орлого, зарлагын 37,450.6 сая төгрөгийн 703 ажил гүйлгээг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4.5-д "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр мэдээлэх" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд хуулиар тогтоосон хугацаанд үнэн зөв, иж бүрэн байршуулж байх албан шаардлага хүргүүлэв.

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн оруулав. Үүнд:

1. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулиар эргэж төлөгдөх цэвэр зээлээс төсөвт төвлөрүүлэхээр 208,464.2 сая төгрөгийн төсөв батлагдсан боловч гүйцэтгэлээр 4000, 100000 айлын орон сууц хөтөлбөрийн эргэн төлөлт 10,158.5 сая, аж ахуй нэгж, байгууллагаас эргэн төлөгдөх 3,039.1 сая, дампуурсан банкнуудын эрх хүлээн авагчаас авах 35,000.0 сая, нийт 48,197.6 сая төгрөгийг төсөвт дутуу төвлөрүүлсэн байна.

Энэ нь Өрийн удирдлагын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.6-д "Дэд болон эцсийн зээлдэгч нь дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээнд заасан төлбөрийг хугацаа хэтрүүлсэн тохиолдолд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх эрхтэй" 32.6.2-д "төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн хувьд тэдгээрийн арилжааны банкин дахь дансыг хаалгах, холбогдох данснаас авлага барагдуулах хэмжээний

хөрөнгийг суутган авах, бусад байгууллагатай харилцан авлагатай бол тухайн байгууллагаас харилцан суутган тооцох" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Төсвийн төслийг бодитой тооцоололд үндэслэн төлөвлөж батлуулах, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах;

2. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Тайлант онд гадаадын зээл, тусламжийн эх үүсвэрээр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 9 ажлын санхүүжилт 49,270.1 сая төгрөгийг захиалагч байгууллагын санхүүгийн тайланд эргэлтийн хөрөнгөнд хуримтлуулан бүртгүүлээгүй, харьяа байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайланд хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн шилжүүлэх зориулалттай хөрөнгө ангилалд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-д "Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна. Төсөвт авсан зээл, хандив, дэмжлэг, тусламжаар бий болсон хөрөнгө үүнд нэгэн адил хамаарна", Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан журам "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам"-ын 6.1-д "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажил нь төрийн, эсхүл орон нутгийн өмчид заавал бүртгэгдэх бөгөөд барилга байгууламжийг барьж дуусах хүртэл, худалдан авах тоног төхөөрөмжийг ашиглалтад хүлээн авсан эцсийн гүйцэтгэлийн дүнгээр захиалагч байгууллага эргэлтийн хөрөнгөөр бүртгэн санхүүгийн тайланд тусгана" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Төсвийн ерөнхийлөн захирагч болон харьяа байгууллагуудын санхүүгийн тайланг уялдаатай нэгтгэх, ТӨХК-ууд болон бусдад оруулсан хөрөнгө оруулалтыг харьяалах төсөв захирагчийн санхүүгийн тайланд бүртгэж, нэгтгүүлэн тайлагнуулах, санхүүгийн нэгтгэсэн тайланд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах;

3. Төсөл хэрэгжүүлэгч нэгжүүдийн бүртгэл, тайлантай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

- Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 119 төсөл хөтөлбөр нэгтгэгдсэнээс 57 төсөл хөтөлбөрт аудит хийж, аудитаар нийт 463,970.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 304,533.4 сая төгрөгийн 114 алдааг аудитын явцад залруулж, 13.5 сая төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт тогтоож, 156,959.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах 59 албан шаардлага хүргүүлж, 2,464.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 64 зөвлөмжийг хүргүүлсэн нь сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нийт алдаа зөрчлийн 96.8 хувийг эзэлж байна.
- Өмнөх оны тайланд бүртгэгдээгүй орхигдсон Инженер технологийн төслийн 119.2 сая төгрөгийн гадаад зээлийн ашиглалтыг тайлант оны төсвийн гүйцэтгэлийн тайланд нөхөж тайлагнасан байна.
- Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 119 төсөл хөтөлбөрийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 12 Төсвийн ерөнхийлөн захирагчид хамаарах 42 төсөл хөтөлбөр нь төслийн нэгжгүй, зөвхөн данснууд бүртгэлтэй бөгөөд эдгээр дансаар хийгдсэн ажил гүйлгээний үр дүнд бий болсон хөрөнгийн бүртгэл, тайлагналд тавих хяналт сул байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.36-д "Төсвийн ерөнхийлөн захирагч" гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах

эрх бүхий этгээдийг; 14 дүгээр зүйлийн 14.2.2-т "Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох", мөн 14.2.7-д "Өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн бусад байгууллага, Засгийн газрын тусгай сан, гадаадын зээл, тусламжаар хэрэгжсэн төслийн тайлан бүхий хагас жилийн болон жилийн эцсийн санхүүгийн тайланг нэгтгэн, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх", 14.2.10-т "Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар батлагдсан "Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам"-ын 25.6-д "ТХН нь төсөл, арга хэмжээний нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн мэдээг нэгтгэн гаргахын өмнө энэхүү журмын 25.2, 25.3-т заасан мэдээг жилийн эцсийн байдлаар, өссөн дүнгээр гарган Сангийн яамны асуудал хариуцсан нэгж болон төв Төрийн сантай нийт зээлийн төслийн ашиглалт, гүйцэтгэлээр тооцоо нийлж, баталгаажуулна" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж:

1. Төсөл хэрэгжүүлэх нэгжийн санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, төсөл хөтөлбөрийн бүртгэл, тайлагналтай холбоотой бодлогын баримт бичгийг боловсруулж, төслийн санхүүгийн ажилтнуудыг сургалтад хамруулж, арга зүйгээр хангаж ажиллах;
2. Төслийн нэгжгүй төсөл хөтөлбөрийн санхүүжилт, төсвийг харьяалах ТЕЗ-ийн төсвийн хуваарьт батлуулж, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах;

4. Төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн Төсвийн тухай хуульд заасан бүрэлдэхүүн хэсгийг хуулиар заасан хугацаанд иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй, зөвхөн эдийн засгийн ангиллаарх төсвийн гүйцэтгэлийг гаргаж, нэмэлт санхүүжилтийн тайлбар, санхүүгийн тайлангийн үгэн тодруулгагүй бэлтгэсэн, төсвийн тохируулгын тайланг Сангийн сайдын тушаалаар батлагдсан маягт аргачлалын дагуу гараагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйл 54.5-д "Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна"; 54.5.1-д "Тухайн жилийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл /нийт дүнгээр, хөтөлбөрөөр, төсвийн захирагчаар, хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрээр/"; 54.5.3-т "Тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл; 54.5.4-т хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/; 54.5.5-д "Нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулга"; Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар батлах журам"-ын 2 дугаар хавсралт; Сангийн сайдын 2012 оны 76 дугаар тушаалаар баталсан "Төсвийн гүйцэтгэлийн тайлан боловсруулах журам"-ын 1 дүгээр хавсралт 1.4-т "Төсвийн эрх захирагч нь төсвийн гүйцэтгэлийн тайланд тайлант оны төсвийн хэтрэлт, хэмнэлт түүнд нөлөөлсөн хүчин зүйлийн талаарх дэлгэрэнгүй тайлбар танилцуулга хавсаргана", 2.3-т "Төсвийн байгууллага нь төсвийн гүйцэтгэлийн тохируулгыг Төсвийн гүйцэтгэлийн тохируулгын 1 а маягтын дагуу гарган төсвийн гүйцэтгэлийн тайлангийн хамт дээд шатны төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

4.2. Өгсөн зөвлөмж:

1. Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтын дагуу төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсгийг иж бүрэн гаргаж, толилуулж хэвших;

2.Төсвийн тухай хууль, Сангийн сайдын тушаалаар батлагдсан журмуудын дагуу санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангуудад тодруулга, танилцуулга тайлбар бэлтгэж жилийн санхүүгийн нэгтгэсэн тайлантай хамт ирүүлж байх;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 09 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Харьяа байгууллагын нэр	Аудитын санал дүгнэлтийн төрөл				Тогтоосон төлбөрийн акт		Өгсөн албан шаардлага		Өгсөн зөвлөмж		Албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал	
		Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ													
1	Сангийн яамны-аппарат	1						1		5	402.4		
ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ													
1	Татварын ерөнхий газар	1						1		1			
	Татварын ерөнхий газрын аппарат					1	146.1			3	382.3		
2	Архангай аймгийн Татварын хэлтэс	1								1			
3	Баян-Өлгий аймгийн Татварын хэлтэс	1				1	0.1						
4	Баянхонгор аймгийн Татварын хэлтэс	1								1	4.3		
5	Булган аймгийн татварын хэлтэс												
6	Говь-Алтай аймгийн Татварын хэлтэс	1				1	3.4	2	11.3	1	2.6		
7	Говьсүмбэр аймгийн Татварын хэлтэс	1						1					
8	Дархан-Уул аймгийн Татварын хэлтэс	1				1	0.3			3	27.1		
9	Дорноговь аймгийн татварын хэлтэс												
10	Дорнод аймгийн Татварын хэлтэс	1						1	3.2				
11	Дундговь аймгийн татварын хэлтэс	1						1	1.7				
12	Завхан аймгийн Татварын хэлтэс	1								1			
13	Өвөрхангай аймгийн Татварын хэлтэс	1						1	75.0				
14	Өмнөговь аймгийн Татварын хэлтэс	1				2	0.9	2	1.8	2			
15	Сүхбаатар аймгийн татварын хэлтэс	1								1			
16	Сэлэнгэ аймгийн Татварын хэлтэс	1								1			
17	Төв аймгийн Татварын хэлтэс	1						1	1.5	4	12.1		
18	Увс аймгийн Татварын хэлтэс	1											
19	Ховд аймгийн Татварын хэлтэс	1								5	8.7		
20	Хөвсгөл аймгийн Татварын хэлтэс	1								1			

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

21	Хэнтий аймгийн Татварын хэлтэс	1											
22	Орхон аймгийн Татварын хэлтэс	1			2	0.9			1	0.6			
23	Хан-Уул дүүргийн Татварын хэлтэс	1							4	6.1			
24	Багахангай дүүргийн Татварын хэлтэс	1					2	0.3					
25	Налайх дүүргийн Татварын хэлтэс	1							2	9.6			
26	Баянзүрх дүүргийн Татварын хэлтэс	1							3	2.3			
27	Сүхбаатар дүүргийн Татварын хэлтэс	1							4	12.7			
28	Баянгол дүүргийн татварын хэлтэс	1							3	38.3			
29	Чингэлтэй дүүргийн татварын хэлтэс	1							3	8.8			
30	Сонгинохайрхан дүүргийн татварын хэлтэс	1							3	16.0			
31	Багануур дүүргийн татварын хэлтэс	1					3	1.1	3	4.1			
32	Нийслэлийн Татварын газар	1							3	16.3			
33	Том татвар төлөгчтэй харилцах газар												
Нийт дүн		30	-	-	-	8	151.7	15	95.8	54	551.9	-	-
1	Гаалийн ерөнхий газар	1								1			
2	Баян-Өлгий дэх гаалийн газар	1								1	11.3		
3	Говь-Алтай гаалийн хороо		1					2	1.44	3		1	
4	Горхи мэлхий хад амралтын газар												
5	Дархан гаалийн газар	1				1	8.2			1	0.9		
6	Дорнод гаалийн газар	1						4	263.4	1			
7	Замын-Үүд гаалийн газар	1								3	30.3		
8	Сайншанд гаалийн газар	1								4	2.0		
9	Завхан гаалийн хороо	1								1			
10	Орхон гаалийн газар												
11	Сэлэнгэ гаалийн газар	1						1	14.3	2	1.8		
12	Сүхбаатар аймгийн Бичигт дэх гаалийн газар	1				1	1.0	1		4	1.8		
13	Улс хоорондын шуудан илгээмжийн газар	1						1	399.5	4	7.8		
14	Үйлчилгээ аж ахуйн алба							1	293.5				
15	Буянт-Ухаа дахь гаалийн газар							1	120.3				
16	Улаанбаатар дахь гаалийн газар	1								3	4.2		
17	Увс гаалийн газар	1						1	4.3	2	3.7		
18	Гаалийн ерөнхий газар-Санхүү хөрөнгө оруулалтын хэлтэс												
19	Ховд гаалийн газар	1								1			
20	Хөвсгөл гаалийн хороо												
21	Гашуунсухайт гаалийн газар	1						1					
22	Шивээхүрэн гаалийн газар												
Нийт дүн		14	1			2	9.2	13	1,096.9	31	63.6	1	-
ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САН													
1	Засгийн газрын нөөц сан	1								1			

2	Засгийн газрын өрийн баталгааны сан												
3	Ирээдүйн өв сан												
4	Төсвийн тогтворжуулалтын сан												
Нийт дүн		1								1	-	-	-
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР													
1	Монголын хөрөнгийн бирж	1								1	1.6		
2	Монголын үнэт цаасны клирингийн төв ХХК	1						1					
3	Үнэт цаас төвлөрсөн хадгаламжийн төв ХХК	1						1		4	142.8		
4	Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв	1						2		2	22.3		
5	Монгол Улсын хөгжлийн банк	1											
6	Төрийн банк	1											
7	Үндэсний давхар даатгал	1											
8	Хадгаламж даатгалын корпорац	1											
Нийт дүн		8						4		7	166.7	-	-
ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ НЭГЖ													
1	Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах хоёр үе шаттай зээлийн төсөл	1						2		4	3.3		
2	Ногоон нуур 1008 айл орон сууц төсөл	1						1		1			
3	Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл	1						1					
4	Тогтвортой амьжиргаа төсөл -3	1						1		1	24.8		
5	Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл	1						1		2	8.5		
6	Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжлийн төсөл	1						1		2	11.0		
7	Монгол улсад засаглалыг бэхжүүлэх төсөл	1						1		2	26.9		
8	Төсөв санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төсөл	1						1		2	266.3		
9	Хөгжлийн хөтөч-дэд бүтэц төсөл	1						2	446.9	6	76.5		
10	Улаанбаатар хотын цэвэр агаар төсөл	1						1		3	17.9		
11	Өндөрхаан нисэх онгоцны буудлыг шинэчлэн барих төсөл	1								2	5.0		
12	Экспортыг дэмжих төсөл	1						3	30.6	2	1.1		
13	Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж /зам барих 3 төсөл/	1											
14	Хөвсгөл нуур байгалийн цогцолборт газрын орчны бүсийн иргэдийн амьжиргааг дэмжих, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх нэгдсэн төсөл”	1											

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

15	Ухаалаг засаглал төсөл	1					2		2	57.2		
16	Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл-I шат	1							2			
17	Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл-II, III шат	1					1		2			
18	Эрүүл мэндийн салбарын хөгжил төсөл хөтөлбөр 4 нэмэлт төсөл	1					1					
19	Цахим эрүүл мэнд төсөл	1					1		2			
20	УБ хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төсөл -2	1										
21	"МУ-ын Зүрх Судасны Үндэсний Төв ба Зүрх судасны тусламж үйлчилгээг уялдуулан сайжруулах нь" МОН-006 төсөл	1										
22	Эрчим хүчний төсөл II		1				3	34,345.0	1			
23	Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл	1					2	6,495.1				
24	Хүнс тэжээл нийгмийн халамжийн нэмэлт санхүүжилт төсөл	1										
25	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл		1				3	6,408.4				
26	Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төсөл	1					2	879.4	4	17.3		
27	Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл	1					1					
28	Бүс нутгийн логиستيкийн төвийг хөгжүүлэх төсөл	1										
29	Боловсролын чанарын шинэчлэл төсөл	1					1	18,107.1	2	30.5		
30	Монгол улсад ковид 19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төсөл	1					1		3			
31	Улаанбаатар Мандалговийн цахим дамжуулах агаарын шугам, дэд станц барих төсөл	1										
32	Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төсөл	1					2	13.5	1			
33	Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төсөл	1					1					
34	"Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин	1										

	газруудын хөгжлийн L3388-MON төсөл I												
35	Баруун бүсийн сургуулийн бага ангийн сурагчдын дотуур байрны нөхцөлийг сайжруулах төслийн	1											
36	Дээд боловсролын шинэчлэлийн төсөл	1					1	4,470.6					
37	Улаанбаатар хотын хүнсний хог хаягдлыг дахин боловсруулах төслийн	1					1						
38	Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл	1					1		1				
39	Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр 5 төсөл	1					1						
40	Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замын хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл-2	1					1	103.9	2	74.7			
41	Зуд болон ой хээрийн түймэртэй тэмцэх олон нийтийн чадавхыг бэхжүүлэх төсөл	1											
42	Бүс нутгийн авто зам хөгжүүлэх засвар арчлалтын төсөл		1				3	3.3					
43	Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт төсөл	1					2	8,435.4	1				
44	Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төслийн нэмэлт санхүүжилт төсөл	1					1						
45	Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй төслийн	1					1						
46	Төсвийн санхүүгийн удирдлага ил тод, үр ашигтай байдал төсөл	1				1	4.6	1					
47	Төлбөрийн системийн шинэчлэл төсөл	1						1	2,048.9	2	9.3		
48	Гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг сайжруулах замаар хөрсний бохирдлыг бууруулах төсөл	1				1	5.4						
49	Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн L3713MON нэмэлт санхүүжилтийн төсөл II*	1											
50	Улаанбаатар хотын дөрөвдүгээр цахилгаан станцын үр ашгийг дээшлүүлэх төсөл	1											
51	Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах төсөл	1						1		1			

